

“ҮНЭТ ДУРСГАЛТ ЗҮЙЛИЙН ЗЭРЭГЛЭЛД НЭР ДЭВШҮҮЛЭХ” ҮЗМЭРИЙН ЖАГСААЛТЫН ТӨСӨЛ

ХЭНТИЙ АЙМГИЙН МУЗЕЙ								
Д/д	Үзмэрийн нэр	Хувийн дугаар	Тоо ширхэг	Хэмжээ	УБМС-ийн дугаар РСН (прораммын)	Судлагдсан сурталчлагдсан байдал	Саналын үндэслэл	СӨҮТ-ийн санал
1	Солир	90-9	1	550.000гр Өн:79 Өр:59 Зу:42	2301ХЭМ0092 2	2010 оны 7-р сард профессор, химич, сэтгүүлч Г.Гонгоржав түүнээс нэгээхэн жижиг дээж авч ШУТИС-ийн Дулааны Техник Үйлдвэрийн экологийн хүрээлэнгийн эрдэм шинжилгээний тэргүүлэх ажилтан, доктор Б.Цэндээтэй хамтран химийн найрлагыг Геологийн төв лабораторид рентгенфлуоресценцийн спектрометрийн физик-хими болон химийн сонгомол аргаар (4.5.6) 2 удаа хийсэн шинжилгээний дүнгийн дунджийг хувиар илэрхийлж, ОХУ-ын "Маркова", "Одесса", "Полуямки" зэрэг чулуун солир (7)-ын химийн найрлагатай харьцуулсан байдаг.	Хэнтий аймгийн музейд Монгол улсын хэмжээнд олдоод байгаа чулуун солирын хамгийн том нь, төмөр ба чулуун солируудаас "Аж Богд-2" /583 кг/ солирын дараа 2-т орох солир хадгалагдаж байгааг шинжлэх ухааны ул суурьтай судалгаагаар баталж өгсөн болно. Энэ судалгаа нь тус үзмэрийн нэр хүндийг өргөсөн төдийгүй шинжлэх ухааны судалгаанд нээлт болохуйц цоо шинэ мэдээ мэдээллийг эрдэм шинжилгээний эргэлтэд оруулснаараа чухал ач холбогдолтой юм. Судлаачид одоогоор солир анх олсон газрын нэрээр "Галшар-Түвшинширээ" хэмээн нэрлээд байна. Мейсоны ангилалын "Н" хэв шинжийн солирт хамаарагдана.	Дэмжсэн
2	Пийсүү чулуун аяга	89-04	2	Өн:7.5см Дм:16.3см	2301ХЭМ0008 1		Сэцэн хан(20 дахь Сэцэн хан) Навааннэрэн(Чингис хааны 19 дүгээр үеийн ач, Халхын анхны Сэцэн хан Шолойгоос хойш 20 дахь үе буюу сүүлчийн удаа хаан ширээ залгамжилсан нь алтан	Дэмжсэн Судлагдсан сурталчлагдсан

							ургийн тайж Цэрэндондовын хөвүүн) хэрэглэж байсан гэж үздэг. Сэцэн ханы ордонд Навааннэрэнгийн хэрэглэж байсан эд зүйлс цөөнгүй хадгалагдаж үлдсэн байдаг бөгөөд тэдгээрийн нэг энэхүү пийсүү чулуун хос аяга юм. Уг хос аягыг 1900 оны эхэн үед Сэцэн хан Навааннэрэн арван хомтой тэмээний хөлсөөр хийлгэж байжээ. Аймгийн музейд хадгалагдах пийсүү чулуун аягыг 1989 онд музейд үзмэр болгон авсан.	байдал дутуу
3	Хошуу наадам	ХЭМ2019.2.1	1	Урт:21см Өр:5.8см	2301ХЭМ0136 5	Ж.Саруулбуян “Сэцэн ханы хүлэг” 1997 он	Хошуу наадам зураг нь Сэцэн хан аймгийн Бишрэлт вангийн хошууны ноён, зураач, хүлэг шинжээч Хардэл жанжин бэйс, олноо Өвгөн ноён хэмээн алдаршсан М.Пүрэвжавын зурсан эх зураг. Энэхүү бүтээл нь хус модны ар, өвөр хоёр талд дүрслэлтэйгээрээ онцлог бөгөөд зургийн өвөр талд хуучин Бишрэл вангийн хошуу одоогоор Галшар сумын Их Арт уул, наадмын том асарт өвгөн ноён өөрийгөө дүрслэн буулгасан гэж нутгийн хөгшчүүд хуучилдаг.	Дэмжсэн
НИЙТ 3 ДЭСИЙН 4 ШИРХЭГ								